

UCS 1403B:2022

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ




Гадна мэдээллийн байгууламжид
тавих ерөнхий шаардлага

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ

Гадна мэдээллийн байгууламжид
тавих ерөнхий шаардлага

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 23-р тогтоолоор батлав.



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ	5
2. Норматив эшлэл.....	5
3. Гадна мэдээллийн байгууламжийн ерөнхий шаардлага	5
4. Гадна мэдээллийн байгууламжид тавих шаардлага	9
5. Гадна мэдээллийн байгууламж байрлуулах.....	10
6. Гадна мэдээллийн байгууламж суурилуулах	12
7. Материал, бүтээцийн шаардлага.....	12
8. Гадна мэдээллийн самбарыг хүлээн авах шалгуур үзүүлэлт	14
9. Хавсралт 1 Нийтийн эзэмшлийн мэдээллийн байгууламжийн дизайн	15
10. Ашигласан материалын жагсаалт.....	16

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Нийтийн эзэмшлийн талбайд байрлуулах гадна мэдээллийн самбар (Жишээ зураг)	6
Зураг 2. Байршлын мэдээллийн самбар (Жишээ зураг).....	7
Зураг 3. Нэгдсэн мэдээллийн самбар (Жишээ зураг)	7
Зураг 4. Нийтийн тээврийн автобусны үйлчилгээний мэдээллийн самбар (Жишээ зураг).....	8
Зураг 5. Түүх, аялал жуулчлалын холбогдолтой мэдээллийн самбар (Жишээ зураг)	9
Зураг 6. Ухаалаг мэдээллийн байгууламж (Жишээ зураг).....	10
Зураг 7. Мэдээллийн байгууламжийн зай хэмжээний шаардлага (Жишээ зураг)	11
Зураг 8. Мэдээллийн байгууламжийн зай хэмжээний шаардлага (Жишээ зураг)	11
Зураг 9. Гадна мэдээллийн байгууламжийг суурилуулах хэсэглэл (Жишээ зураг)	12
Зураг 16. Мэдээллийн байгууламжийн загвар (Жишээ зураг).....	15

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Мэдээллийн байгууламжийн эдлэхүүний өнгөний төрөл	12
Хүснэгт 2. Хийцлэлийн төрөл, үзүүлэлт	13
Хүснэгт 3. Хүлээн авах шалгуур үзүүлэлт.....	14



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 24-өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

Г Нийтийн эзэмшлийн эд хөрөнгөд хамаарах хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10^1 дүгээр зүйлийн $10^1.1$ дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө бүлэгт хамаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

1.1. UCS1402B:2022 “Нийтийн эзэмшлийн талбайд байгуулах усан оргилуурт тавих ерөнхий шаардлага” хотын стандартыг

1.2. UCS1401B:2022 “Нийтийн бие засах газрын төлөвлөлт байгуулалтад тавих техникийн шаардлага” хотын стандарт

1.3. UCS1403B:2022 “Гадна мэдээллийн байгууламжид тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.4. UCS 1404B:2022 “Саравч, сүүдрэвчинд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.5. UCS1405B:2022 “Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага” хотын стандарт

1.6. UCS1406B:2022 “Нийтийн эзэмшлийн зам талбайн хогийн саванд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.7. UCS1407B:2022 “Нийтийн эзэмшлийн зам талбайн сандалд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.8. UCS1408B:2022 “Хөшөө дурсгал, хүндэтгэлийн самбарт тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.9. UCS1409B:2022 “Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлт, тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.10. UCS1410B:2022 “Хашаа, хайс, хашлаганд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1110100320

2.Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.

3.Энэхүү тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.





НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ

UCS 1403B:2022 “ГАДНА МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛАМЖИД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандарт нь нийтийн эзэмшийн талбайд гадна мэдээллийн байгууламжийг байгуулахад дагаж мөрдөнө. Зар сурталчилгааны самбар барилга үл хөдөх хөрөнгийн хаяг авто замын тэмдэгт энэ стандарт үйлчлэхгүй.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах хууль, барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- MNS 5283 : 2022 Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага;
- MNS 6775:2019 – Хаяг, Хаягийн бичвэрт тавих шаардлага;
- MNS 5217:2017 – Монгол кирилл үсгийн латин хөрвүүлэг;
- Гадна хаяг, мэдээллийн байгууламжид тавигдах шаардлага батлах тухай Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2014 оны 09 сарын 19-ний өдрийн А/148 тушаал;
- Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журам Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 9/10 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт.

3. ГАДНА МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛАМЖИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

3.1. Ерөнхий шаардлага:

3.1.1. Гадна мэдээллийн байгууламж нь MNS 5283:2022 Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага, MNS 6775:2019 – Хаяг, Хаягийн бичвэрт тавих шаардлага, MNS 5217:2017 – Монгол кирилл үсгийн латин хөрвүүлэг зэрэг стандартын үзүүлэлт, шаардлагуудыг бүрэн хангасан байх ба дараах нэмэлтээр заасан шаардлагуудыг хангасан байна.

3.1.2. Гадна мэдээллийн байгууламж нь хот төлөвлөлт, хотын архитектур дизайны шийдэл, иргэдийн болон авто замын хөдөлгөөний аюулгүй байдал, хэл бичгийн стандарт, шаардлагад нийцсэн байна.

- 3.2. Гадна мэдээллийн байгууламжийг нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд зорчиж байгаа иргэд, үйлчлүүлэгчдийг мэдээллээр хангахад зориулан, хотын өнгө үзэмж, иргэдийн эрүүл аюулгүй орчны нөхцөлийг хангасны үндсэн дээр байрлуулна.
- 3.3. Гадна мэдээллийн байгууламжийг нийтийн эзэмшлийн гудамж талбайд байрлуулах бол зохих журмын дагуу зөвшөөрөл авсан байна.



Зураг 1. Нийтийн эзэмшилийн талбайд байрлуулах гадна мэдээллийн самбар (Жишээ зураг)


- 3.4. Мэдээллийн самбарт байрласан мэдээлэх хэсэг нь хүний харааны түвшинд байвал зохино.
- 3.5. Мэдээллийн самбар нь орчин үеийн технологийн шийдлийг ашиглан аудио болон видео дүрст нэмэлт тоноглолоор тоноглогдсон байж болох бөгөөд шөнийн цагт мэдээллийг харах боломжийг бүрдүүлсэн байна.
- 3.6. Гадна мэдээллийн байгууламжид стандарт хэмжээ заахгүй.
- 3.7. Байршлын мэдээллийн самбар
 - 3.7.1. Байршлын мэдээллийн самбар гэж нийтийн эзэмшилийн талбайд байршуулсан маршрут болон чиглэл заасан шинж чанартай байх бөгөөд тодорхой объектын мэдээллүүд болон, нэг цэгээс нөгөө цэг хүртэл явган хүн, тээврийн хэрэгслээр туулах замын урт болон хугацааг заасан самбарыг хэлнэ.
 - 3.7.2. Байршлын мэдээллийн самбарт тухайн мэдээлэл байрлуулсан цэг, ойролцоо гудамжны нэр, замын сүлжээ, нийтийн тээврийн зогсоолын байршил болон чухал шаардлагатай барилга, үйлчилгээний байршил, зүг чигийг харуулсан байна.
 - 3.7.3. Байршлын мэдээллийн самбарыг явган хүний замын гол цэгүүдэд болон нийтийн тээврийн зогсоолын ойролцоо, орчны аюулгүй байдлыг хангасны үндсэн дээр байрлуулсан байна.



Зураг 2. Байршлын мэдээллийн самбар (Жишээ зураг)

3.8. Байгууллагын нэгдсэн мэдээллийн самбар


- 3.8.1. Олон аж ахуйн нэгж, байгууллага нэг байшинд байрладаг бол тухайн аж ахуйн нэгж байгууллагын нэр, байршил бусад мэдээллийг агуулсан нэгдсэн байгууламжийг байгууллагын нэгдсэн мэдээллийн самбар гэнэ.
- 3.8.2. Нэгдсэн мэдээллийн самбар нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 3.8.2.1. барилгын давхар бүрийг доороос нь дээш нь цувуулан бичиж тухайн давхарт байрлах аж ахуйн нэгжийн лого, албан газрын нэрийг бичнэ;
 - 3.8.2.2. аль нэг байгууллага солигдох, мэдээлэл нь шинэчлэгдэх үед хялбар өөрчилж болох шийдэлтэй байна;
 - 3.8.2.3. металл хийц хэсгүүд зэвэрдэггүй материалыаар хийгдсэн аль эсвэл зэврэлтээс хамгаалах будаг түрхлэг стандартын дагуу хийгдсэн байна.



Зураг 3. Нэгдсэн мэдээллийн самбар (Жишээ зураг)

3.9. Нийтийн тээврийн үйлчилгээний мэдээллийн самбар

- 3.9.1. Нийтийн тээврийн маршрут заасан самбар гэж тухайн буудалд ирэх нийтийн тээврийн хэрэгслийн зорчих маршрут болон, хугацааг заасан цогц самбарыг хэлнэ.
- 3.9.2. Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоол, буудал дахь байгууламжууд нь орчиндоо зохицсон, эрх бүхий байгууллагын батлагдсан зураг төслөөр, өнгө үзэмжтэй гэрэлтүүлэгтэй хийгдсэн байна.
- 3.9.3. Мэдээллийн самбар нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:
- 3.9.3.1. автобусны зогсоолын нэр;
 - 3.9.3.2. үйлчилгээний цагийн хуваарь, хүлээх цагийн давтамж;
 - 3.9.3.3. маршрутын дугаар, маршрутын зураглал
 - 3.9.3.4. нийтийн тээврээр үйлчлүүлэхтэй холбогдсон аяллын мэдээллүүд;
 - 3.9.3.5. яаралтай үед ашиглах утасны дугаар
 - 3.9.3.6. шаардлагатай бусад нэмэлт мэдээлэл
- 3.9.4. Нийтийн тээврийн автобусны үйлчилгээний мэдээллийн самбарыг “Нийтийн тээврийн автобусны зогсоолд тавих өрөнхий шаардлага” UCS 1601B-д заасны дагуу төлөвлөж байгуулна.



Зураг 4. Нийтийн тээврийн автобусны үйлчилгээний мэдээллийн самбар (Жишээ зураг)

3.10. Түүх, аялал жуулчлалын холбогдолтой мэдээллийн самбар

- 3.10.1. Соёлын өвийг сурталчлах таниулах зорилгоор онцлог түүх, баримт бусад мэдээллийг агуулсан байгууламжийг хэлнэ.
- 3.10.2. Тогтсон стандарт хэмжээ заахгүй бөгөөд архитектур талаасаа тухайн газрын уур амьсгалд нийцсэн, загвар, өнгө үзэмжтэй байна.



Зураг 5. Түүх, аялал жуулчлалын холбогдолтой мэдээллийн самбар (Жишээ зураг)

4. ГАДНА МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛАМЖИД ТАВИХ ШААРДЛАГА

4.1. Бичвэрийн шаардлага

- 4.1.1. Гадна мэдээллийн байгууламжийн бичвэрийг Засгийн газрын 2013 оны 37 дугаар тогтоолын дагуу Монгол хэл /кирилл/-ээр үг, үсгийн алдаагүй бичих ба Үндэсний бичиг /уйгуржин/-ээр бичиж болно.
- 4.1.2. Шаардлагатай нөхцөл /бараа, бүтээгдэхүүний нэр, лого нь зохиогчийн эрхээр баталгаажсан, гадаадын иргэд олноор үйлчлүүлдэг/-д гадна хаяг, мэдээллийн байгууламжийн бичвэрийг англи хэлээр бичих ба бичвэр нь монгол бичвэрийн доод талд байрлаж, түүнээс 2 дахин бага өндөртэй байх эсвэл монгол /кирилл/ бичвэрийн зүүн гар талд байрлаж, түүнтэй ижил өндөртэй байна.
- 4.1.3. Аль нэг байгууллага солигдох, мэдээлэл нь шинэчлэх үед мэдээллийг хялбар өөрчилж болох шийдэлтэй байна.

4.2. Зураглалын шаардлага

- 4.2.1. Нийтийн эзэмшлийн мэдээллийн байгууламжид байрлуулах зураглалд дараах гэрэл зураг, график зураглал, газрын зургийн шаардлага тавигдана. Үүнд:

Дүрс, тэмдэг – Хялбаршуулсан жижиг график зургууд нь агуулж буй мэдээллийн ойлголтуудыг богино хугацаанд ойлгогдохоор хялбаршуулсан дүрслэн харуулсан тэмдэг, тэмдэглэгээ байна.

Зураг, зураглал – Зураг зураглалыг мэдээлэлд ашиглах нь нэмэлт текстийг хэмнэж, утга агуулгыг сайн ойлгоход туслах бөгөөд, энгийн дүрсэлсэн агуулгатай байна.

Газрын зураг – Тухайн байршил, эхлэх цэгээс очих газрын маршрут, явганаар болон тээврийн хэрэгслээр туулах замын урт, хугацаа зэргийг үзүүлж, орон зайн хэмжээс болон түүний бодит хэмжээний харьцааг ойлгогдохууццаар илэрхийлж, чухал шаардлагатай барилга, байгууламж үйлчилгээний мэдээллийг таних тэмдэг тайлбартайгаар үзүүлж, зүг чигийн сумыг байрлуулсан байна.

4.3. Загвар дизайны шаардлага

- 4.3.1. Нийтийн эзэмшлийн талбайд байршуулах мэдээллийн байгууламжийн загвар дизайныг тухайн орчны барилга байгууламжийн архитектурын онцлог, өнгө үзэмжид тохируулан хийнэ.
- 4.3.2. Гадна мэдээллийн байгууламжийг байрлуулах барилгын даац, гадна фасадын бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй байхын зэрэгцээ хууль ёсны өмчлөгчөөс нараас албан ёсоор зөвшөөрөл авсан байна.
- 4.3.3. Гадна мэдээллийн байгууламж нь явган хүний эргономик болон хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй байдлын шаардлагыг хангасан байна.
- 4.3.4. Цахилгаан болон аюулгүй ажиллагааны холбогдох норм, стандартад нийцсэн байна.

4.4. Нэмэлт медиа тоноглол

- 4.4.1. Мэдээллийг үр дүнтэй, хялбар хүргэх дуу, дүрс болон ухаалаг мэдрэгчтэй дэлгэц, бусад тоног төхөөрөмжөөр тоноглогдсон ухаалаг мэдээллийн байгууламжийг байгуулж болно.




Зураг 6. Ухаалаг мэдээллийн байгууламж (Жишиг зураг)


5. ГАДНА МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛАМЖ БАЙРЛУУЛАХ

- 5.1. Гадна мэдээллийн байгууламжийг явган хүний замд саад учруулахгүй, авто замын уулзваруудын хажууд, нийтийн тээврийн зогсоол, үзвэр, үйлчилгээний газар, нийтийн бие засах газар зэрэг нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байрлуулна.

- 5.2. Гадна мэдээллийн байгууламжийг нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байрлуулах нөхцөлд дараах хэм хэмжээг баримтална. Үүнд:
- 5.2.1. Автомашин болон явган хүний хөдөлгөөнд саад учруулахгүй, үзэгдэх орчин хязгаарлахгүй байх;
 - 5.2.2. Автозамын хэвтээ проекцоос 1 метрээс багагүй зайд байрлуулах бөгөөд авто зам, инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажил хийгдэхээр төлөвлөж байгаа газарт байрлуулахгүй байх;
 - 5.2.3. Барилгын хана, фасад дээвэрт байрлах нөхцөлд тухайн барилга болон хөрш зэргэлдээ объектын цонх, хаалга, үзэгдэх орчин халхлахгүй байх.
- 5.3. Гадна мэдээллийн байгууламж нь замын хөдөлгөөний болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналтын камер, хөдөлгөөн зохицуулах гэрэл дохио, авто замын тэмдгийн үзэгдэх орчныг халхлахгүй байх ёстой. Зай хэмжээний шаардлагыг Зураг 7-д үзүүлэв.



Зураг 7. Мэдээллийн байгууламжийн зайд хэмжээний шаардлага (Жишээ зураг)




Зураг 8. Мэдээллийн байгууламжийн зайд хэмжээний шаардлага (Жишээ зураг)

- 5.4. Хэрэв барилга нь замаас хол зйтай бол хоёр самбартай байх нь зүйтэй бөгөөд, нэг нь замын ойролцоо тойм мэдээллийг унших боломжтой, нөгөө нь барилгын үүдний ойролцоо илүү дэлгэрэнгүй мэдээллийг харуулдаг байвал зохино.
- 5.5. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр нийтийн эзэмшлийн зам, талбай болон бүх төрлийн холбоо, цахилгаан, гэрэлтүүлгийн шон зэрэгт мэдээллийн байгууламж байрлуулахыг хориглоно.
- 5.6. 1 ба 2 дугаар зэрэглэлийн гудамж талбайд авто замын тусгаарлах зурvasaас бусад газар 3х6 м-ээс том самбар тавихыг хориглоно.
- 5.7. Иргэд оршин суугчид, бусад байгууллагуудын цонх харагдах орчныг халхалж, байгалийн гэрэл ашиглах боломжийг хязгаарлахгүй байвал зохино.
- 5.8. Мэдээллийн самбарыг нийтийн эзэмшлийн талбай гудамжинд суурилуулахдаа ногоон байгууламжийн мод, бутны хэмжээ, тэдгээрийн байршил, ургалтын хэв маягийг анхаарах хэрэгтэй.

6. ГАДНА МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛАМЖ СУУРИЛУУЛАХ

- 6.1. Гадна мэдээллийн байгууламжийг суурилуулахдаа орчны аюулгүй байдлыг хангана.
- 6.2. Гадна мэдээллийн байгууламжийг газарт хөдөлгөөнгүй суурилуулах бөгөөд суурийн бетон эдлэлд зөвхөн тэлэгч боолт ашиглаж газрын гадаргад бэхэлнэ.
- 6.3. Гадна мэдээллийн байгууламжийн үндсэн хийц эдлэхүүний нийт жингээс хамааруулан суурийн бетон эдлэлийн хэмжээг тооцно.
- 6.4. Гадна мэдээллийн байгууламжийн багана болон бусад холбох хэрэгслүүд нь бат бөх, чанарын стандарт, шаардлага хангасан байх ёстой бөгөөд гэмтэх эрсдэлийг тооцоолсны үндсэн дээр суурилуулна.
- 6.5. Мэдээллийн байгууламжийг нийтийн эзэмшлийн гудамж, талбайд суурилуулахдаа ногоон байгууламжийн мод, бутны хэмжээ, тэдгээрийн байршил, ургалтын хэв маягийг анхаарах хэрэгтэй.



Зураг 9. Гадна мэдээллийн байгууламжийг суурилуулах хэсэглэл (Жишээ зураг)

7. МАТЕРИАЛ, БҮТЭЭЦИЙН ШААРДЛАГА









- 7.1. Гадна мэдээллийн байгууламжийн металл хийц хэсгүүдийг зэвэрдэггүй материалаар хийх, зэврэлтээс хамгаалах будаг түрхлэгийг стандарт шаардлагад нийцсэн будгаар технологийн дагуу будсан байна. Мэдээллийн байгууламжид тохирох өнгөний сонголтыг Хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1. Мэдээллийн байгууламжийн эдлэхүүний өнгөний төрөл

№	Нэр, тэмдэглэгээ	Өнгө	Өнгөний код /CMYK/
1	Мөнгөлөг RAL9006		C – 15, M – 10, Y – 10, K – 0
2	Цайвар саарал RAL7046		C – 30, M – 10, Y – 0, K – 0
3	Саарал RAL9001		C – 25, M – 20, Y – 50, K – 0
4	Цагаан		C – 0, M – 0, Y – 0, K – 0
5	Хар		C – 0, M – 0, Y – 0, K – 100

7.2. Мэдээллийн байгууламжийн металл хийцлэл материалын төрөл, үзүүлэлт:

Хүснэгт 2. Хийцлэлийн төрөл, үзүүлэлт

№	Материалын нэр	Төрөл, марк	Зузааны хэмжээ	Огтлолын хэмжээ, мм	Ханын зузааны хэмжээ, мм	Хундийн хэмжээ, м/кг
1	Дөрвөлжин металл яндан	 Зураг 10. (Жишээ зураг)		A=30x30	S=1.5-2.0	1.07-1.39
2	Дөрвөлжин металл яндан	 Зураг 11. (Жишээ зураг)		A=50x50	S=1.5-2.5	0.64-1.5
3	Тэгш өнцөгт металл яндан	 Зураг 12. (Жишээ зураг)		A=40x25	S=1.5-2.5	0.64-1.5
4	Тэгш өнцөгт металл яндан	 Зураг 13. (Жишээ зураг)		A=60x30	S=1.5-2.5	1.07-2
5	Зууван металл яндан	 Зураг 14. (Жишээ зураг)		A=45x28 A=38x25	S=1.5-2.5	1.32-1.73
6	Дугуй металл	 Зураг 15. (Жишээ зураг)		D=50		1.13-3.5

8. ГАДНА МЭДЭЭЛЛИЙН САМБАРЫГ ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Гадна мэдээллийн байгууламжид тавигдаж байгаа материал, үйлдвэрлэлийн шаардлага, хэмжээ, загвар, байрлуулах, суурилуулах шаардлагыг хангаж байгаа эсэхийг хүлээн авах шалгуур үзүүлэлт (Хүснэгт 3.)-ийн дагуу хянан шалгаж хүлээн авна.

Хүснэгт 3. Хүлээн авах шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Нийтийн эзэмшлийн талбайд байрлуулсан мэдээллийн байгууламж нь автомашин болон явган хүний хөдөлгөөнд саад учруулахгүй, үзэгдэх орчныг хязгаарлаагүй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Мэдээллийн байгууламж нь замын хөдөлгөөний болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналтын камер, хөдөлгөөн зохицуулах гэрэл дохио, авто замын тэмдгийн үзэгдэх орчныг халхлаагүй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Авто замын байгууламжийн хэвтээ проекцоос 1 метрийн зйттай эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Мэдээллийн байгууламж нь гудамж зам талбай, барилгын загвар дизайнд тохирсон үзэмжтэй байх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Мэдээллийн байгууламжийг инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний хамгаалалтын зурваст байрлуулаагүй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Мэдээллийн байгууламжийн металл хийц хэсгүүд зэвэрдэггүй материалыар хийгдсэн, эсхүл зэврэлтээс хамгаалах будаг түрхлэг стандартын дагуу хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Мэдээллийн байгууламж нь гадна, эсхүл дотор гэрэлтүүлэгтэй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Цахилгаан болон барилга угсралтын аюулгүй ажиллагааны талаарх холбогдох норм, стандартыг баримталсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
9	Мэдээллийн байгууламжийг газарт хөдөлгөөнгүй бэхэлж, тэлэгч боолт ашиглаж газрын гадаргад бэхэлсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Нийтийн эзэмшлийн талбайд байрлуулах мэдээллийн байгууламж нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

ХАВСРАЛТ 1. НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛАМЖИЙН ДИЗАЙН



Зураг 16. Мэдээллийн байгууламжийн загвар (Жишээ зураг)

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журам /Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 9/10 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт/
- Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий Нийтийн тээврийн зогсоолын төлөвлөлт БД 32-101-17
- Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм БНБД 12-03-04
- Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам /Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолын хавсралт/
- Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам
- Монгол кирилл үсгийн латин хөрвүүлэг MNS 5217:2017
- Цахилгаан техникийн байгууламжийн угсралтын дүрэм ЭХД-2-20-01-2013
- Цахилгаан техникийн байгууламжийн угсралтын аюулгүй ажиллагааны дүрэм ЭХД-1-12-04-2013
- MNS 5283 : 2022 Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага
- MNS 6775:2019 – Хаяг, Хаягийн бичвэрт тавих шаардлага

 Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР

 Хан-Уул дүүрэг, 23-р хороо, 17100, Наадамчдын зам
1200, Нутгийн захиргааны цогцолбор байр.

 70118030, 70118040

 www.standard.ub.gov.mn

 Хотын стандарт, хяналтын газар